



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 12 сарын 17 өдөр

Дугаар А/809

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ын "в", Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Халаалтын улиралд оршин суугчдаас халаалтын шугам сүлжээ, халаалттай холбоотой өргөдөл гомдол жил бүр ирсэнтэй холбогдуулан аймгийн төвийн дулааны станцын тоноглолуудын технологи ажиллагааг хянаж үйлдвэрийн ус, анхдагч үүсгэвэр усанд хими биологи технологийн шинжилгээ хийх үйлчилгээний хөлсөд 500 000 төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх арга хэмжээнд зарцуулах 500 000 төгрөг /таван зуун мянга/-ийг аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2021 оны 4/03 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтын 4.11-д заасан "Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах" дэд хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга /Б.Баярсүх/ нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч /Т.Жаргалсайхан/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ